

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: Улсын аварга малчин
өрхөд олгох цом нийлүүлэх хязгаарлагдмал тендер
Тендер шалгаруулалтын дугаар: ТШ/2021/03/УАМӨНЦ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Улсын аварга малчин өрхийн шагналд олгох цом нийлүүлэх эрх бүхий тендерт оролцогчдоос битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2019, 2020 оны борлуулалтын орлогын дундаж нь захиалагчийн төсөвт өртгийн 40 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Захиалагчийн төсөвт өртгийн 40 хувиас дээш байх тухай нотлох баримтыг ирүүлнэ.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2 жил буюу 2019- 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ирүүлнэ.

Сүүлийн 2 жилд нийлүүлсэн ижил төстэй барааны өртөг: Захиалагчийн төсөвт өртгийн 40 хувиас багагүй байна.

Тендерт санал болгож буй үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 40 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.
Дотоодын давуу эрх тооцохгүй.

Тендерийг нээлт хийх хаяг: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам,
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө-16/А, Засгийн
газрын 9/А дугаар байр, 4 дүгээр давхар, 403 тоот өрөө

Сонирхсон этгээд тендертэй холбогдох мэдээллийг 51-263247 утсаар авч болно.